

МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХАРИЛЦАА: ШИНЭ ЧИГЛЭЛ, ШИНЭ ТҮНШҮҮД

Ц. Гомбосүрэн*

Ардчилсан шинэчлэлийн өмнөхөн үеийн Монголын гадаад харилцааны байдал

Гадаад бодлогын шинэ чиглэл, шинэ түншийн тухай ярихын тулд өмнөх байдлыг товч боловч авч үзье. Өнгөрсөн зууны 80-90-ээд оны зааг манай гадаад харилцаа, гадаад бодлого төдийгүй улс орны нийт амьдралын хувьд эргэлтийн чанартай үе болсон билээ. Энэ нь, нэгдүгээрт, тус улсын оршин тогтнож байсан гадаад орчин ойрын хийгээд арай өргөн хүрээнд үндсээрээ өөрчлөгдөх болсноос үүдэлтэй, нөгөөтэйгүүр тэрхүү өөрчлөлтийн нөлөөгөөр, бас өөрийн дотоод хөгжлийн шалтгаанаар манайд өрнөсөн зарчмын шинэ үйл явцаар нөхцөлдсөн юм.

80-аад оны дунд үеэс хуучин Зөвлөлт Холбоот Улсад өөрчлөн байгуулалт гэж нэрлэгдсэн үйл явц эхэлж, тэр нь олон улсын харилцааны болон дотоодод хуримтлагдсан хүчин зүйлсийн харгайгаар эцэстээ ЗХУ задран нурж, тэр улс 1991 оны сүүлчээр байхгүй болсон. Үүний улмаас хоёр туйлт ертөнцийн нэг нь болж байсан дэлхийн социалист систем гэдэг олон улсын харилцааны цоохор ч гэсэн нөлөө бүхий нэгэн субъект алга болсон. Уг системийн цэрэг улс төрийн гол байгууллага - Варшавын гэрээний байгууллагыг 1991 оны долдугаар сарын эхээр, эдийн засгийн гол байгууллага - Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөлийг мөн оны зургаадугаар сарын эцсээр тус тус татан буулгасан. Зүүн Европын социалист гэгдэж байсан орнууд ардчилал шинэчлэлийн замд шуудран орсон. Олон жил хүйтэн дайны билэг тэмдэг болж байсан Берлины хана нурж хоёр Герман нэгдсэн.

Энэ систем, түүний ноён нуруу болж байсан ЗХУ хоёр л чухамдаа тэр үеийн Монгол улсын оршин тогтнох гадаад эерэг орчинг бараг дангаараа тодорхойлж байсан.

* Гадаад хэргийн сайд асан, Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд

Ингэж хэлж байгаа маань тухайн үеийн өвөрмөц байдлыг цохох гэсэн хэрэг болохоос олон улсын харилцааны бусад субъекттэй барьж байсан харилцаанаас, олон улсын харилцаанд бидний татагдан орж байсан бусад орон зайнаас Монголд үзүүлж байсан бас бус нааштай нөлөөг үгүйсгэж байгаа хэрэг биш.

Улс төрийн үүднээс яривал, Монгол улс социалист хамтын нөхөрлөлийн уялдуулсан зохицуулсан гадаад бодлого гэгчийг ягштал даган биелүүлэгч байлаа. Монголд зөвлөлтийн цэрэг байрлаж байлаа. Тус улсын худалдаа, эдийн засгийн харилцааны гол түншүүд ч тэрхүү социалист орнууд. Манай гадаад худалдааны эргэлтийн 95 орчим хувь нь эдгээр оронд ноогдож байлаа. Гаднын зээл тусламж бараг зуун хувь тэднийх. Гэхдээ энэ харилцааны үр өгөөж дорвитой нэмэгдэхгүй, хамтын ажиллагааны механизм, ялангуяа ЭЗХТЗ-ийн хүрээнд “хий эргэх” нь улам бүр элбэгшиж байсан. Социалист орнуудын харилцаанд ямар ч бэрхшээл, өө сэв байх ёсгүй мэтээр сурталдаж, үүсч буй болсон төвөгтэй асуудлуудаа илэн далангүй зарчимчаар хэлэлцэн шийдвэрлэхийн оронд “асуудлыг хурцатгахгүй байх, эвийг олох” нэрийдлээр бүрхэгдүүлэн аргацаах буюу улам бүр даамжруулах хандлага газар авч байлаа. Хэдий тийм боловч социалист систем, ЗХУ нуран унасан нь Монголын оршин тогтнохын үндсийг бүрдүүлж байсан гадаад орчин алга болсон буюу шал өөр болсон хэрэг юм.

Нөгөө талаас, хориод жилийн турш хэвийн бус явж ирсэн Монгол, Хятадын харилцаа, түүнчлэн “империалистуудын хорон бодлого” болон түүний үр дагавар гэгдсэн хүйтэн дайн манай гадаад орчны сөрөг хэсгийг бүрдүүлж байлаа.

Энэхүү сөрөг хэсгийн орнуудад манай гадаад худалдааны эргэлтийн дөнгөж тав орчим хувь оногдож байлаа. Улс төрийн харилцаа үндсэндээ ёс төдий байдалтай. Эдгээр орноос нэлээдтэй нь хэлэлцээр, протокол юм уу төлөвлөгөөний үндсэн дээр соёлын харилцаа хэрэгжүүлж байсан боловч тэр нь зарим нэг арга хэмжээг эс тооцвол хэмжээ дайлайцаар бага, агуулгаар ядмаг, ихэнхдээ бэлэгдлийн шинжтэй байжээ гэж хэлж болно. Хүмүүнлэгийн харилцааны тухайд гэвэл эрдэмтэд, судлаачдын зарим нэг хэлхээ холбоог эс тооцвол нааштай гэхээр зүйл чухамдаа нэн ховор. Хөрөнгөтөн орнуудтай энх тайвнаар зэрэгцэн орших зарчмын үндсэн дээр харилцана гэж тунхагладаг боловч ерөөс гадаад бодлогын агуулгыг ангийн тэмцлийн үзэл тодорхойлт байсан учраас социализмын давуу талыг нотлох зорилгоос үүдэн нөгөө энх тайвнаар зэрэгцэн орших бодлого маань хэрэг дээрээ сөргөлдөх үзэл санааны барьцаанд байсан гэхэд хилсдэхгүй биз.

Энд товч дурдаж буй хэдхэн зүйл нь тэр үеийн Монгол улсын гадаад бодлогын өрөөсгөл шинжийг харуулж байгаа бөгөөд тийм болгосон хүчин зүйлсийн дотроос ангич байр суурь, үзэл сурталжсан онолын үндэс, тэдгээрээс үүдэн үндэснийхээ язгуур эрх ашгийг системийнхээс доогуур тавих зарчим, системийн бодлогыг даган өөрт холбогдолгүй буюу улсынхаа хэр чинээнээс хэтэрсэн асуудлаар хөөцөлдөх гажиг зэргийг юуны түрүүнд нэрлэх ёстой. Тиймэрхүү бодлогынхоо уршгаар бид ертөнцийн нэлээд хэсэгт, ялангуяа өндөр хөгжилтэй орнуудын дунд “дагуул улс”, “хаалттай орон” гэдэг нэр хаягтай болж явлаа.

Шинэ нөхцөл байдал, шинэ орон зайд оновчтой байрших шаардлагын дагуу явуулсан үйл ажиллагаа

ЗХУ болон социалист систем задран унахын өмнө Зөвлөлтийн улс төрийн шинэ сэтгэлгээ гэдэг гадаад бодлогын номлол таван жил орчим хэрэгжсэн билээ. Энэхүү бодлогын үр дүнд ЗХУ-ын “Брежневийн номлол” гэгдсэн, социализмын үйл хэргийг хамгаалах нэрийдлээр нөгөө орнуудынхаа дотоод хэрэгт оролцохыг зөвтгөсөн агуулгатай, социалист орнуудын бүх талын ойртон нягтралт гэдэг хаягтай бодлого чухамдаа улиран замхрах замдаа орсон гэж хэлж болно. Энэ тухайд хожим М.С.Горбачев “ЗХУ “Брежневийн номлол” гэгч бодлогыг хэзээ ч албан ёсоор тунхаглаж байгаагүй ч холбоотон орнууддаа чухамхүү тэр үүднээс хандаж ирсэн ... бид тэр бодлогоос татгалзсан нь тухайн орны эрх баригч нам улс орныхоо бүхий л байдлын хариуцлагыг бүрэн хүлээнэ гэсэн үг байсан юм”¹ гэж бичсэн билээ.

Улс төрийн шинэ сэтгэлгээний бодлогын дагуу социалист орнууд, тэдгээрийн дотор Монгол улс гадаад харилцаандаа ангийн эрх ашгийн үүднээс бус нийт хүн төрөлхтний үнэт зүйлсийг эрхэмлэсэн, өөрөөр хэлбэл, үндэсний эрх ашгаа өмнөө барьсан бодлого явуулах боломж тодорхой хэмжээгээр нээгдсэн юм. Үүнийг нотлох жишээ болгож 1987 онд АНУ-тай, 1989 онд Европын Холбоотой дипломат харилцаа тогтоосон болон 1987, 1989 онуудад Монгол, Японы гадаад хэргийн сайд нар харилцан айлчилсныг дурьдаж болох юм. Өөрөөр хэлбэл, Монгол улсын гадаад харилцааны орчин бага боловч эрхбиш тэлж эхэлсэн гэсэн үг.

Нөгөөтэйгүүр, хоёр системийн харилцааны агуулгыг олон жилийн турш тодорхойлж ирсэн хүйтэн дайны байдал Зөвлөлтийн шинэ бодлогоос ихэвчлэн шалтгаалж

¹ М.С. Горбачев, *Жизнь и реформы*, М., 1995, 311-312 дугаар тал

80-90-ээд оны зааг дээр үндсэндээ төгсвөр болсон. Ийнхүү олон улсын харилцаа эрс өөрчлөгдөж, дэлхий дахины улс төрийн уур амьсгал зөөлөрсөн нь тус улсын гадаад орчин таатай байдлаар бүрэлдэх бас нэг хүчин зүйл болсон юм.

Ийнхүү, нэг талаас хамтын ажиллагааны гол түншүүд маань хөгжлийн өөр замд шилжиж, бидний харилцааны хуучин зарчим үйлчлэхээ больсон, нөгөө талаас олон улсын уур амьсгал зөөлөрсөн нь Монгол улсын гадаад бодлогын шинээр томъёолон хэрэгжүүлэх шаардлагыг дэвшүүлэн тавьсан юм. Үүнд багцалж яривал хоёр том зорилт тулгарсан: нэгдүгээрт, хуучин социалист орнуудтай, ялангуяа ЗХУ-тай хөгжүүлж байсан харилцаанд хуримталсан сөрөг үр дагаврыг аль болохоор богино хугацаанд оновчтой засч залруулах, эерэг өвийг шинэ нөхцөл байдал, шинэ зорилттой уялдуулан бататгах, хоёрдугаарт, даруй шинэ түншүүдтэй болж, тус орны улс төр, эдийн засгийн гадаад орчны онгойсон зайг нөхөх.

Эдгээр зорилтыг практик дээр 80-90-ээд оны зааг үеэс хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд тус улсын гадаад бодлогын зарчим, тэргүүлэх чиглэлүүдийг 1992 оны шинэ Үндсэн хууль, 1994 онд баталсан Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлалаар тодорхойлсон билээ. Уг үзэл баримтлалд Монгол улс нээлттэй, эвсэлд үл нэгдэх, олон тулгуурт гадаад бодлого явуулахыг заахын хамт гадаад бодлогын тэргүүлэх чиглэлүүдийг дараах байдлаар тодорхойлсныг өнөө хүртэл мөрдөж яваа билээ. Үүнд:

- 1). ОХУ, БНХАУ-тай харилцаатай байх нь Монгол улсын гадаад бодлогын эн тэргүүний зорилт мөн;
- 2). Монгол улсын гадаад бодлогын хоёр дахь чиглэл бол АНУ, Япон, ХБНГУ зэрэг өрнө, дорнын өндөр хөгжилтэй орнуудтай найрсаг харилцаа хөгжүүлэх явдал мөн;
- 3). Монгол улсын гадаад бодлогын гурав дахь чиглэл бол Азийн бүс нутагт байр сууриа бататгаж, эндхийн улс төр, эдийн засгийн интеграцид оновчтой оролцох явдал мөн;
- 4). Монгол улсын гадаад бодлогын дөрөв дэх чиглэл нь Нэгдсэн Үндэстний Байгууллага болон түүний төрөлжсөн салбарууд, Олон улсын валютын сан, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг санхүү-эдийн засгийн байгууллагуудтай хамтран ажиллах явдал байна;
- 5). Социалист хамтын нөхөрлөлийн гэгдэж байсан орнууд, Тугаар улсуудын хамтын нөхөрлөлийн орнуудтай найрсаг харилцаа хөгжүүлэх нь Монгол улсын гадаад бодлогын тав дахь чиглэл байна;

6). Хөгжиж байгаа орнуудтай найрсаг харилцаатай байж, нийтлэг зорилтоо шийдвэрлэх үүднээс бодит боломжийн хэмжээнд тэдгээртэй хамтран ажиллах явдал Монгол улсын гадаад бодлогын зургаа дахь чиглэл байна.

Ийнхүү гадаад бодлогын эн тэргүүний зорилт нь хоёр хөрштэй харилцах бодлого гэж тодорхойлогдох болсон байна.

Манай орны амьдралд ЗХУ буюу Монгол-Зөвлөлтийн харилцааны гүйцэтгэж байсан үүргийг бодолцох юм бол энэ харилцааг, хожмоо үүнийг залгамжилсан Монгол, Оросын харилцааг шинэчлэн төвхнүүлэх явдал тухайн үеийн үнэхээр том зорилт байв.

Монгол, Зөвлөлтийн харилцаанд даруй шийдвэл зохих олон асуудал хуримтлагдсан байснаас хамгийн чухал нь хэмээн Зөвлөлтийн цэргийг гаргах, хоёр орны харилцааны түүхийн “балархай” хуудсыг тодруулж олон нийтийг үнэн зөв мэдээлэлтэй болгох, ЗХУ-д хальж гарсан Монголын соёлын өвийг эгүүлэн авах, гадаад худалдааны үнийн “хайчийг” арилгах, өр авлагын асуудлыг шийдэх зэргийг дурьдаж болно. Эдгээрээс манай гадаад харилцааны бусад чиглэлийн шинэ зорилтыг шийдвэрлэхэд Зөвлөлтийн цэргийг гаргах явдал онцгой ач холбогдолтой асуудал байсан юм. Тухайлбал, уг асуудлыг шийдэхгүйгээр БНХАУ-тай харилцааг хэвийн болгож хөгжүүлэх, Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөнд гишүүнээр элсэх (тухайн үед тавигдаж байсан чухал зорилт) зэрэг асуудлыг нааштай шийдвэрлэх боломжгүй байсан байна. Зөвлөлтийн цэргийг Монголоос бүрэн гаргах асуудлаар хоёр тал 1989 оны эцсээр зарчмын тохиролцоонд хүрч, 1992 оны эцсээр Зөвлөлтийн сүүлчийн танк, сүүлчийн цэрэг нутаг буцжээ. Ер нь Зөвлөлтийн 82 мянган цэргийн албан хаагч (гэр бүлийн хамт 100 мянга гаруй хүн), 1866 танк, 2531 байлдааны хуягт машин, 315 байлдааны нисэх онгоц, нисдэг тэрэг, 1416 их буу, миномётыг 1987-1992 онд² тус тус гаргажээ.

Дурьдсан бусад асуудлаар тэр үедээ улс төрийн дээд болон бусад олон шатанд удаа дараа яриа хэлэлцээр хийж, хальж гарсан соёлын өвөөс бусад чиглэлээр зохих үр дүнд хүрсэн буюу хоёр тал нэгдмэл ойлголттой болжээ. Хоёр орны харилцаанд “их өр” хэмээгдсэн эмзэг асуудлыг 2003 оны сүүлчээр харилцан боломжтой гэж үзсэн хувилбараар эцэслэн шийдвэрлэсэн байна.

Эдүгээ Монгол, Оросын харилцаа, хамтын ажиллагаа 1993 оны найрсаг харилцааны гэрээ болон хожим хоёр талын дээд хэмжээний айлчлалуудын үеэр байгуулсан улс төрийн өндөр тунхаглалуудын үг үсэг, үзэл санааны дагуу тогтвортой

² Монгол цэргийн түүхийн товчоон, дэд дэвтэр, УБ., 1996, 496 дугаар тал

хөгжиж байна. Улс төрийн өндөр болон дээд хэмжээний яриа хэлэлцээ тогтмолжиж, худалдаа, эдийн засгийн харилцаа цаашид өргөжих хандлагатай болж байна. Хуучин ЗХУ манай худалдаа, эдийн засгийн гол түнш байсан бол ОХУ тэр байр суурийг нэгэнт алдсан. 2004 оны байдлаар ОХУ манай гадаад худалдааны хоёрдугаар түншийн эрэмбэтэй (362.5 сая ам. доллар буюу 18.4%), 1990 оноос хойш оруулсан хөрөнгө оруулалтаар (37.2 сая ам. доллар буюу 3.3%) д явж байнадолдугаар байран. Одоо Оросын талын хөрөнгө оруулалт бүхий 300 орчим аж ахуйн нэгж Монголд ажиллаж байна. Соёл, хүмүүнлэгийн харилцааны эерэг уламжлал сэргэн идэвхжих төлөвтэй байна.

Монгол, Хятадын харилцаа хоёр талын сонирхол нийлсэн хүч чармайлтын үрээр 90-ээд оны эхнээс үндсэндээ бүрэн хэвийн болсон. Үүний нэг тод нотолгоо нь 1994 оны Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны гэрээ юм. Эдүгээ хоёр орны харилцаанд шийдэгдээгүй зарчмын чанартай асуудал байхгүй. БНХАУ манай гадаад худалдааны хамгийн том түнш, гол хөрөнгө оруулагч орон болоод байна. 2004 оны байдлаар хоёр орны худалдаа 632.0 сая ам. долларт хүрсэн буюу манай гадаад худалдааны нийт эргэлтийн 33.4% болсон байна. 1990 оноос хойш оруулсан хөрөнгө оруулалтаар (447.3 сая ам. доллар буюу 39.6%) нэгдүгээр байранд явж байна. 2005 оны эхний байдлаар Хятадын 1600 гаруй аж ахуйн нэгж Монголд хөрөнгө оруулсан байна. Монгол, Хятадын бусад салбарын хамтын ажиллагаа ч амжилттай урагшилж байна. Товчдоо, тус хоёр орны хамтын ажиллагаа манай гадаад харилцааны томоохон хүчин зүйлийн нэг нэгэнт болжээ.

Монгол улс өөрчлөлт шинэчлэлийн жилүүдэд гадаад бодлогынхоо хоёр дахь чиглэл буюу АНУ, Япон, ХБНГУ зэрэг өрнө, дорнын өндөр хөгжилтэй орнуудтай харилцаа хөгжүүлэх талаар зарчмын ач холбогдолтой амжилт олжээ. Тэдгээр улс Монголын ардчилсан өөрчлөлтийг эхнээс нь улс төр, эдийн засгийн гэхчлэн бүхий л талаар тууштай дэмжиж, манай гадаад орчинд үүссэн хоосон орон зайг нөхсөн билээ. Чухамхүү тэр дэмжлэг манай ололт амжилтын нэг ёсны баталгаа болж ирсэн гэж хэлэх бүрэн үндэстэй.

Чухамхүү тэдгээр улсын идэвх санаачлагатай үйл ажиллагааны үрээр Монголд хандивлагч орнуудын бүлэг бүрдэж, тэдний санхүүгийн тусламж манай шилжилтийн үеийн хамгийн хүнд үеийн бэрхшээлийг даван туулахад төдийгүй өнөөгийн хөгжлийн асуудлыг урагшлуулахад шийдвэрлэх хүчин зүйлийн нэг болсоор байна. Үүнтэй холбогдуулан АНУ-ын Монголд явуулсан бодлогын талаар арай дэлгэрэнгүй авч үзэх нь зүйтэй гэж бодож байна.

Монгол, Америкийн харилцаа идэвхтэй хөгжих эхийг АНУ-ын тэр үеийн Төрийн нарийн бичгийн дарга Ж.Бейкерийн 1990 онд манай оронд хийсэн айлчлал тавьсан. Ж.Бейкер АНУ-ын засаг захиргаа Монголын ардчилал, шинэчлэлийн үйл явцыг тууштай дэмжинэ гэдгийг нотлож, тодорхой хэдэн зүйлийг амласан. Тухайлбал, Монголыг олон улсын санхүүгийн байгууллагуудад гишүүнээр элсэхэд дэмжлэг үзүүлэх, зах зээлийн эдийн засгийн удирдлага, шинэ тогтолцооны эрх зүйн үндсийг бүрдүүлэх, ардчилсан нийгмийн институцийг бий болгох зэрэг салбарт туслалцаа үзүүлэхээ амласан. Монгол улсын төрийн тэргүүнийг АНУ-д айлчлуулах асуудлыг тэр айлчлалын үеэр хоёр тал тохиролцсон. Монгол, Америкийн анхны гэрээ хэлэлцээр ч мөн тэгэхэд байгуулагдсан (Монгол, Америкийн Консулын конвенц, “Энх тайвны корпус”-ын шугамаар хамтран ажиллах хэлэлцээр байгуулж, Худалдааны хэлэлцээрийг үзэглэсэн). АНУ Монголын гурав дахь хөршийн зиндаанд байж болох тухай санааг Ж.Бейкер чухамхүү энэ айлчлалынхаа үеэр илэрхийлсэн.

Монгол улсын төрийн тэргүүн П.Очирбат 1991 оны 1 дүгээр сард АНУ-д түүхэн айлчлал хийсэн. Энэ айлчлалаар олон зүйл тохиролцсон буюу шийдсэн. Социалист систем бутран унасны дараа бараг ганцаардлын байдалд орох шахаж байсан Монгол улс ардчилал шинэчлэлийг нь дэлхийн бодлогынхоо хүрээнд тал бүрээр тууштай дэмжих хүчирхэг түнштэй болж байгааг уг айлчлал харуулсан. АНУ-ын Конгрессийн хоёр танхим Ерөнхийлөгчийнхөө саналыг үндэс болгон 1991 оны 3 дугаар сард Монголын ардчилал шинэчлэлийг дэмжсэн тогтоол гаргасан. Үүний ач холбогдол ойлгомжтой. Мөн Америкийн бодлогын ачаар Монгол 1991 оны 2 дугаар сард Олон улсын валютын сан, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкны гишүүнээр элссэн. Үүний ач холбогдол бас ойлгомжтой.

Ж.Бейкерийн 1991 онд хийсэн хоёр дахь айлчлал бас тодорхой үр дүнтэй болжээ. Тэрээр АНУ-ын зүгээс Монголд санхүүгийн тусламж үзүүлэх дунд хугацааны бүхэл бүтэн хөтөлбөрөөс гадна олон улсын санхүүгийн байгууллага, хөгжингүй орнуудын дунд Монголд туслах хөдөлгөөн өрнүүлж, хөрөнгө хуримтлуулах ажлыг тодорхой зохион байгуулах саналтай ирсэн билээ. Сүүлчийнх нь санал бол Монголд хандивлагч улс, байгууллагуудыг бүрдүүлж ажиллагааг эхлүүлэх санаа байсан юм. Тэрхүү бүлгийг үүсгэн бүрдүүлэх хэрэгт НҮБ, түүний Хөгжлийн Хөтөлбөр хошуучлах үүрэг гүйцэтгэсэн. 1991 оны 5 дугаар сард Хөгжлийн Хөтөлбөрийн удирдлагаас Европ болон Ази, Номхон далайн бүсийн хорь гаруй өндөр хөгжилтэй орны НҮБ-д суугаа байнгын төлөөлөгч нарт захидал

бичиж, Монгол улсын эдийн засаг, санхүүгийн тусламж авч байсан гадаад эх үүсвэр нь байхгүй болж хүнд байдалд орсныг таниулан, цаг үеийн болон хэтийн туслалцаа үзүүлэхэд хамтран ажиллахыг уриалсан. Мөн энэ үеэр Монголоос НҮБ-ын дэргэд сууж байсан Байнгын төлөөлөгч М.Дүгэрсүрэнгийн санаачлагаар Ерөнхий сайд Д.Бямбасүрэн дээрх зарим орны төлөөлөгчидтэй Нью-Йоркт уулзаж, уг санааг урагшлуулах талаар чухал алхам хийжээ.

Хожмын хандивлагчдыг уриалан зохицуулах үүргийг эхний үед НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, Япон хоёр хүлээсэн юм. Цаашдаа Япон гол зохицуулагч болсон байна. Дурьдсан зохицуулагчид болон АНУ-ын хүч чармайлт чухал үүрэг гүйцэтгэснээр хандивлагчдын анхны зөвлөлдөх уулзалт 1991 оны 10 дугаар сард Улаанбаатар хотноо болж, хандивлагчдын бүлгийг бүрдүүлэх цаашдын дүр зураг тодорхой болжээ. 1996 он гэхэд энэ бүлэглэлд 20 гаруй улс, 10 шахам олон улсын байгууллага хамрагдсан байв. 2000 он хүртэлх хугацаанд болсон хандивлагчдын 7 уулзалтаас Монголд 2 тэрбум гаруй ам. долларын зээл тусламж амалсны 70 гаруй хувийг тухайн үед нь ашигласан байна.

Эдүгээ Монгол, Америкийн харилцаа, хамтын ажиллагаа иж бүрэн түншлэл гэж томъёологдох хэмжээ рүү явж байна. 2005 онд Америкийн Ерөнхийлөгч Ж.Буш манай оронд айлчилсан нь түүхэн үйл явдал болсон байна. АНУ 1990 оноос хойшхи хугацаанд Монголд 15 сая гаруй ам. долларын хөгжлийн тусламж үзүүлжээ. 2006 оны байдлаар Монгол, Америкийн худалдааны эргэлт 160 сая орчим ам. доллар байсан буюу АНУ манай худалдааны дөрөвдүгээр түнш болжээ. 1990 оноос хойш Америкийн 110 компани 88 сая ам. долларын хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд энэ үзүүлэлтээр АНУ дөрөвдүгээр байранд явж байна. Монгол улс Ерөнхийлөгч Ж.Бушийн санаачилсан “Мянганы сорилтын сан” хөтөлбөрөөс тусламж авах болзлыг хангасан бөгөөд энэ тухайн гэрээг хоёр тал энэ жил байгуулахаар ажиллаж байна.

Монгол, Японы харилцаа өнөөгийн манай гадаад харилцааны томоохон бүрэлдэхүүн хэсэг болоод байна. Монгол улс өөрчлөлт шинэчлэлийн жилүүдэд Японтой харилцаа хөгжүүлэхэд ихээхэн анхаарал тавьсан, Япон ч манай ардчилсан шинэчлэлийг бүр эхнээс нь дэмжих бодлогыг тууштай хэрэгжүүлсэн. Дээд болон бусад түвшингийн айлчлал, яриа хэлэлцээр тогтмолжсон. Ерөнхийлөгч Багабандийн 1998 онд хийсэн айлчлалын үеэр “Монгол, Японы найрамдал, хамтын ажиллагааны тухай хамтарсан мэдэгдэл”-д хоёр орны харилцааг иж бүрэн түншлэлийн хэмжээнд хөгжүүлэх зарчмыг тунхаглажээ. Япон өнгөрсөн хугацаанд Монголд хамгийн том хандивлагч болсон

(хандивлагчдын бүлгийг зохицуулж ирснийг дээр дурдсан). Японы засгийн газар 1991-2004 оны хооронд 1.3 тэрбум ам. долларын зээл, тусламж үзүүлсний 53.4% нь буцалтгүй тусламж, 28.3% нь хөнгөлөлттэй зээл, 18.3% нь техникийн хамтын ажиллагаа байжээ. 2004 оны байдлаар Японы пүүс компаниудын нийт хөрөнгө оруулалт 65.9 сая ам. долларт хүрч, энэ үзүүлэлтээр 4 дүгээр байранд байна. Мөн оны байдлаар хоёр орны худалдаа 108.4 сая ам.доллар хүрсэн нь бас 4 дүгээрт орсон гэсэн үг юм.

Монгол Европын холбоотой 1989 онд дипломат харилцаа тогтоосон бол 1992 онд худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулснаар манай улс тус Холбооны хөнгөлөлтийн системд хамрагдах болсон. Мөн ЗХУ-ын буурин дээр үүссэн улсуудад туслах зорилготой ТАСИС хөтөлбөртөө, дараа нь Латин Америкийн орнуудыг дэмжих хөтөлбөртөө Монголыг хамруулах зэргээр манай шинэчлэлийг идэвхтэй дэмжиж ирлээ. Европын холбоо 2004 оны байдлаар манай худалдааны гурав дахь түншийн байранд явж байв. Мөн 2001-2004 онд 12 сая гаруй ам. долларын буцалтгүй тусламж үзүүлжээ. ЕХ-ны улсуудтай Монгол улс өөрийн боломжийн хүрээнд үндсэндээ идэвхтэй харилцаа барьж байна.

Үүнээс **Германыг** Европ дахь манай гол түнш хэмээн хамтын ажиллагаагаа 1995 онд байгуулсан Монгол, Германы найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тунхаглалын дагуу хөгжүүлж байна. Германы Холбооны Ерөнхийлөгч Р.Херцог 1998 онд Монголд айлчилсан нь “Их долоо”-гийн бүлгийн орнуудын анхны төрийн тэргүүний айлчлал болсон юм. 2005 оны байдлаар хоёр орны худалдааны эргэлт 44 сая гаруй ам. долларт хүрсэн. Германы засгийн газраас 1991-2005 онуудад олгосон нийт 224 сая орчим еврогийн зээл тусламжийн 105.6 сая нь хөнгөлөлттэй зээл, 91.5 сая нь буцалтгүй тусламж байжээ. 2005 оны байдлаар нийт 8.7 сая ам. долларын хөрөнгө оруулалттай Германы 100 гаруй аж ахуйн нэгж Монголд бүртгэгдсэн байна.

Франц, Их Британи, Итали, Дани, Нидерланд, Швейцарь, Австри зэрэг Европын орнууд, Канад, Австрали зэрэг бусад бүс нутгийн зарим орон манай хандивлагчид болж, одоо харилцан ашигтай хамтын ажиллагаа өрнөн хөгжиж байгааг дурдах төдийгөөр хязгаарлая.

Монгол Ази тивийн улс атал социализмын үед энэ өргөн уудам бүс нутагт зохих байр сууриа олигтой эзэлж чадаагүй байсан нь мөн дээр дурьдсан өрөөсгөл бодлоготой маань холбоотой. 1988 оны байдлаар Азийн орнуудтай хийсэн худалдаа манай гадаад худалдааны эргэлтийн дөнгөж 3.2%-ийг эзэлж байжээ. Азийн улсуудын гуравны нэгтэй

нь албан ёсны харилцаагүй байсан. Энэ тивд хандсан бодлогоо идэвхжүүлэх гэсэн зарим нэг оролдлого нь гол төлөв улс төржсөн шинжтэй, бодитой бус, дээр нь “хөндлөнгийн даалгаврын” хам шинжтэй байсан гэж хэлж болохоор байдаг билээ. Тэгвэл эдүгээ байдал эрс өөр болжээ. Монгол улс шинэ гадаад бодлогынхоо хүрээнд энэ тивийн 7 улстай дипломат харилцаа тогтоосон бөгөөд тэдгээрийн дотроос БНСУ, Израиль, Арабын Нэгдсэн Эмират гурав манай идэвхтэй харилцдаг түншүүд болоод байна. Мөн хуучин ёс төдий харилцаа барьж байсан Кувейтийг нэгэн шинэ түнш гэхээр идэвхтэй харилцаж байна. Мөн Монгол, Энэтхэгийн харилцааны агуулга баяжин, цар далайц нэмэгдсээр байна.

Эдгээрээс **Өмнөд Солонгостой** хөгжүүлж буй харилцааг тусгайлан дурьдах нь зүйтэй гэж бодож байна. Манай хоёр орны хооронд бүх шатны, түүний дотор дээд болон өндөр хэмжээний яриа хэлэлцээ тогтмолжоод байна. Энэ бол улс төрийн харилцан ойлголцсон дотно харилцааны илрэл юм. БНСУ-ын засгийн газар 1990-2005 оны хооронд манай улсад 54 сая ам. долларын хөнгөлттэй зээл, 15 сая ам. долларын буцалтгүй тусламж үзүүлсэн байна. Хоёр орны худалдааны эргэлт 2005 оны байдлаар 126 сая ам. долларт хүрчээ. Мөн оны байдлаар Солонгосын талын хөрөнгө оруулалттай 900 гаруй компани бүртгэгдсэн, тэдгээрийн оруулсан хөрөнгийн хэмжээ 106.4 сая ам. доллар болсон байжээ. Манай олон мянган иргэд Өмнөд Солонгост албан ба албан бусаар хөдөлмөр эрхэлж байгаа нь тус хоёр орны харилцааны нэг өвөрмөц хүчин зүйл юм.

Шинэ харилцаа хөгжүүлж буй улс орнуудтай зөвхөн улс төр, худалдаа, эдийн засгийн салбарын харилцааны талаар өнгөц төдий зарим тоо баримтыг дурьдах төдийгөөр хязгаарлав. Тэдгээр оронтой соёл, шинжлэх ухаан техник, цэрэг, хүмүүнлэгийн зэрэг олон салбарт их бага хэмжээний хамтын ажиллагаа хөгжүүлж байгаа бөгөөд тэр нь нийт харилцааны чухал бүрэлдэхүүн хэсэг болж буйг нөхөд мэдэж байгаа нь тодорхой.

Манай гадаад бодлогын үзэл баримтлалд заасан дөрөв дэх чиглэл болох НҮБ болон түүний төрөлжсөн байгууллагуудтай харилцах тухайд шинэ уур амьсгал бий болсон. Энэ асуудлаар жич илтгэл тавигдах учир энд хагас хугас юм ярих шаардлагагүй нь ойлгомжтой. Түүнчлэн бүс нутгийн болон Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн, НАТО зэрэг өргөн хүрээтэй байгууллагуудтай харилцах талаар нэлээд шинэ алхмууд хийгдсэн гэдгийг дурдах төдийгөөр энэ чиглэлийг хязгаарлаж байна.

Мөнхүү үзэл баримтлалын 5, 6 дугаар чиглэлээр шинэ түнш гэсэн ойлголтын хүрээнд хамруулж онцгойлон авч үзэх зүйл байхгүй мэт гэж үзсэнийг минь зөвөөр ойлгох буй за.

Монгол улс өнгөрсөн хугацаанд дотоодод хэрэгжүүлсэн өөрчлөлтийнхөө үзэл санааны дагуу, мөн олон улсын харилцаанд бий болсон шинэ нөхцөл байдлын дагуу гадаад бодлогынхоо тэргүүлэх чиглэлүүдийг шинэчлэн тогтоож, тэдгээрийг хэрэгжүүлэх талаар чадах чинээгээр идэвхтэй үйл ажиллагаа явуулсны үр дүнд нэг талаас, нөгөө талаас манай оронд өрнөсөн ардчилсан өөрчлөлтийг дэлхийн хамтын нийгэмлэг, түүний дотор өрнө, дорнын өндөр хөгжилтэй орнууд тууштай дэмжсэний үрээр дэлхийн ардчилсан улсуудын гэр бүлд багтах болж, Азийн орны нүүр царайг олж, олон улсын байр суурь нь бэхжин батжив. Дэлхийн хүчирхэг улс гүрнүүдийн бодит сонирхол Монголд бүрэлдэж эхэлж байна. Энэ бүхэн бол манай аюулгүй байдал бэхжиж байна гэсэн үг юм.